Кённам мужийн сурагчдад зориулсан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл

Дугаар 26-01 (2026 оны 1-р улирал)

Шинэ хичээлийн жилд эрүүл мэндээ бэлдэж вакцинд

Шинээр сургуульд орсон сурагчдын заавал хамрагдах вакцины мэдээлэл

Нярай болон багадаа хийлгэсэн вакцины дархлаа цаг хугацаа өнгөрөхөд сулардаг. Сургуульд орсон хүүхдээ халдварт өвчнөөс хамгаалахын тулд заавал хийлгэх вакциныг бүрэн хийлгэнэ үү.

Бага сургуулийн сурагчид



DTaP(Сахуу, татран, хөхүүл ханиад) 5 дахь тун,
IPV(Полио) 4 дэх тун,
MMR(Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын) 2 дахь тун,
Япон тархины үрэвсэл 4 дэх тун (идэвхгүй вакцин) эсвэл 2 дахь тун (амьд вакцин)

2019онд төрсөн



Tdap(Сахуу, татран, хөхүүл ханиад) 6 дахь тун (эсвэл Td),
Япон тархины үрэвсэл 5 дахь тун (идэвхгүй вакцин) эсвэл 2 дахь тун (амьд вакцин),
HPV(Хүний папиллома вирус) 1 дэх тун

Вакцинжуулалтын туслах сайт (https://nip.kdca.go.kr) → вакцины лавлагаа

Томуугийн вакцин (Инфлюэнза) – Түгээмэл асуулт, хариулт

Q Өнгөрсөн жил (2025 оны 10-р сар) вакцин хийлгэсэн. Энэ жил (2026 оны 3-р сар) дахин хийлгэх хэрэгтэй юу?

A Үгүй. Томуугийн вакцин нь улирлын (9-р сараас дараа жилийн 4-р сар хүртэл) хугацаанд хүчинтэй байдаг.
Өнгөрсөн намар хийлгэсэн бол энэ хавар хүртэл хамгаалалт үргэлжилнэ.
(Дараагийн зөвлөмжит хугацаа: 2026 оны намар)

Q Томуугийн вакцин хийлгэсэн ч гэсэн томуугаар өвдөж болдог гэж сонссон. Тэгвэл яагаад хийлгэх хэрэгтэй вэ?

A Вакцин хийлгэвэл өвдсөн ч хөнгөн хүрдэг, мөн уушгины хатгаа зэрэг хүндрэлээс сэргийлэх боломжтой.



Вакцинд хамрагдахын өмнө ба дараа анхаарах зүйлс

Вакцинд хамрагдахын өмнө



Биеийн байдал сайн байгаа өдөр эмнэлэгт очих



Насанд хүрээгүй хүүхэд заавал асран хамгаалагчтайгаа хамт очих
Асран хамгаалагч хамт очих боломжгүй өсвөр насны хүүхэд :

1. Асран хамгаалагчийн зөвшөөрлийн хуудас*
2. Эмнэлгийн урьдчилсан асуулгын хуудас урьдчилан бөглөж авчрах**

*Эдгээрийг Вакцинжуулалтын туслах цахим хуудас-аас татаж авах боломжтой.
**Вакцинжуулалтын туслах цахим хуудсаар дамжуулан урьдчилсан цахим асуулгын хуудсыг бөглөх боломжтой.

Вакцинд хамрагдсаны дараа



Тарилга хийлгэсний дараа 20–30 минут эмнэлэгт байж, гаж нөлөө ажиглах



Дараагийн вакцины хугацааг шалгах (урьдчилан сануулах үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой)



Өндөр халуурах, хүчтэй өвдөх зэрэг шинж илэрвэл




1. Эмнэлэгт хандаж зөвлөгөө авах
2. Эрүүл мэндийн төвд мэдээлэх эсвэл вакцинжуулалтын цахим хуудсаар дамжуулан “дархлаажуулалтын дараах гаж нөлөө” хэсэгт мэдээлэх

경상남도 GYEONGNAM
경상남도 감염병관리지원단 Gyeongnam Center for Infectious Disease Control and Prevention
경상남도교육청 GYEONGSANGNAMDO OFFICE OF EDUCATION
경상남도가족센터 GYEONGSANGNAMDO FAMILY CENTER

Хичээл эхэлсний дараа нэмэгдэж болзошгүй өвчин: Салхин цэцэг

Салхин цэцэг гэж ямар өвчин вэ?

Маш өндөр халдвартай вирусээр халддаг өвчин



Халдвар дамжих зам



Өвчтэй хүнтэй шууд Хүрэлцэх




халдвартай хүн ханиах, найтаах үед

Нууц үе

Ихэвчлэн 10–21 хоног (дунджаар 14–16 хоног)



Гол шинж тэмдэг



Хөнгөн халуурах, ядрах → Нүүр эсвэл биеэр туурч эхэлж → Гар, хөлрүү тархана → Жижиг улаан толбо (бага зэрэг товгор) → цэврүү → идээтэй цэврүү → хатаж хальс үүсч эдгэнэ



Хэзээ хүртэл халдвартай вэ?

- Тууралт гарахаас 1–2 хоногийн өмнөөс
- Бүх цэврүү хатаж хальс үүсэх хүртэл





Салхин цэцэг оношлогдвол ‘гэртээ тусгаарлана’

(сургуульд явж болохгүй)

- Бүх тууралтанд хальс үүсэх хүртэл сургуульд явахгүй (тууралт гарснаас хойш хамгийн багадаа 5 хоног)
- хэрэв зөвхөн улаан толбо гарч, хальс үүсэхгүй бол: 24 цагийн турш шинэ ууралт гарахгүй болтол тусгаарлахыг зөвлөдөг



Гэрийн арчилгаа

- Боломжтой бол жорлонг тусдаа ашиглах
- Аяга таваг, алчуурыг тусад нь хэрэглэх



Эмнэлэгт очихдоо

- Урьдчилан утсаар яриад очих
- Маск зүүх
- Бусад өвчтөнд ойртохгүй байх



Халдвар авсан хүнтэй ойр байсан бол

- 72 цагийн дотор вакцин хийлгэхийг зөвлөж байна
- 21 хоног шинж тэмдгийг ажиглах

Салхин цэцгээс сэргийлэх дүрэм



Дархлаажуулалтын бүртгэлээ шалгаж, хийлгээгүй бол вакцин хийлгэх



Урсгал усаар савангаар 30 секундээс дээш гараа угаах



Ханиах, найтаах үед ам хамраа салфетка эсвэл ханцуйгаар дарах



Байнга хүрдэг зүйлсийг цэвэрлэж ариутгах



Сэжигтэй шинж тэмдэгийг ажиглах Халуурах, тууралт гарах зэрэг шинж илэрвэл сургуульд явахгүй, эмчид үзүүлэх

경상남도 GYEONGNAM
경상남도 감염병관리지원단 Gyeongnam Center for Infectious Disease Control and Prevention GNCDC
경상남도교육청 GYEONGSANGNAMDO OFFICE OF EDUCATION
경상남도가족센터 GYEONGSANGNAMDO FAMILY CENTER